



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2007 оны 02 сарын 06 өдөр

Дугаар 27

Төрийн ордон. Улаанбаатар хот

Тодорхой ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулах тухай

Ашигт малтмалын тухай хуулийн 8.1.4 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь :

1.Энэ тогтоолын нэгдүгээр хавсралтад заасан ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулсугай.

2.Тогтоолын нэгдүгээр хавсралтад заасан Монгол Улс, ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрээр ашиглаж байгаа Эрдэнэтийн зэс-молибдений орд, Монгол Улсын Засгийн газраас бусад хөрөнгө оруулагчтай байгуулсан тогтвортой байдлын гэрээгээр үйл ажиллагаа нь зохицуулагдаж байгаа Төмөртэйн овооны цайрын орд, Нарийн сухайтын нүүрсний орд, Бороогийн алтны үндсэн ордын одоогийн ашиглаж байгаа нөхцөлийг хэвээр хадгалах нь зүйтэй гэж үзсүгэй.

3.Тогтоолын хоёрдугаар хавсралтад заасан ашигт малтмалын ордын болон энэ тогтоол батлагдсанаас хойш нөөц нь илэрсэн ордуудын нөөцийг нарийвчлан тогтоож, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулах эсэх тухай саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлж шийдвэрлүүлж байхыг Засгийн газар /М.Энхболд/-т даалгасугай.

4.Стратегийн ач холбогдол бүхий Оюу толгой, Таван толгой, Цагаан суварга, Асгатын ашигт малтмалын ордуудын төрийн эзэмшлийн хувь хэмжээ, түүнийг хэрхэн эзэмших талаархи саналыг эхний ээлжинд боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газар /М.Энхболд/-т үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Ц.НЯМДОРЖ

Монгол Улсын Их Хурлын 2007 оны 27
дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

д/д	Ордын нэр	Ашигт малтмалын төрөл	Байршил	Тайлбар
1	Таван толгой	Чулуун нүүрс	Өмнөговь, Цогтцэций	Тавантолгой ХК, Энержиресорс ХХК, Дайцуки ХХК-ийн эзэмшиж байгаа тусгай зөвшөөрлийн хэмжээнд нөөц тооцсон талбайг хамааруулна.
2	Нарийн сухайт	Нүүрс	Өмнөговь, Гурвантэс	Монгол Улсын Засгийн газартай тогтвортой байдлын гэрээ байгуулсан.
3	Багануур	Хүрэн нүүрс	Улаанбаатар, Багануур	Нөөц тооцсон талбайг хамааруулна. "Багануур" ХК олборлодог.
4	Шивээ Овоо	Хүрэн нүүрс	Говьсүмбэр, Шивээговь	Нөөц тооцсон талбайг хамааруулна. "Шивээ Овоо" ХК олборлодог.
5	Мардай	Уран	Дорнод, Дашбалбар	Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн бөгөөд хувийн хөрөнгөөр нэмэлт хайгуул хийж байна.
6	Дорнод	Уран	Дорнод, Дашбалбар	
7	Гурван булаг	Уран	Дорнод, Дашбалбар	
8	Төмөртэй	Төмрийн хүдэр	Сэлэнгэ, Хүдэр	Уг ордын тусгай зөвшөөрлийг "БЛТ" ХХК эзэмшиж байсныг 2006 онд цуцалсан. Нөөц тооцсон талбайг хамааруулна.
9	Оюу толгой	Зэс, молибдени	Өмнөговь, Ханбогд	Ордын нөөцийн тооцоо бүхий тайланг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцэхэд бэлтгэж байна. Бүлэг ордын хэмжээгээр ойлгоно.
10	Цагаан суварга	Зэс, молибдени	Дорноговь, Мандах	Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн бөгөөд хувийн хөрөнгөөр нэмэлт хайгуул хийж байна.
11	Эрдэнэт	Зэс, молибдени	Орхон, Баян-Өндөр	Монгол Улс-ОХУ-ын Засгийн газар хоорондын гэрээгээр зохицуулагдаж байгаа.
12	Бүрэнхаан	Фосфорит	Хөвсгөл, Алаг-Эрдэнэ	Хөвсгөлийн их дархан цаазат газрын гадна ногдох

13	Бороо	Алт	Сэлэнгэ, Баянгол	Монгол Улсын Засгийн газартай тогтвортой байдлын гэрээ байгуулсан.
14	Төмөртэйн овоо	Цайр, хар тугалга	Сүхбаатар, Сүхбаатар	Монгол Улсын Засгийн газартай тогтвортой байдлын гэрээ байгуулсан.
15	Асгат	Мөнгө	Баян-Өлгий, Ногооннуур	Монгол Улс-ОХУ-ын Засгийн газар хоорондын гэрээ бүхий хамтарсан Монголросцветмет нэгдэл тусгай зөвшөөрлийг нь эзэмшиж байгаа.